



Америкийн Нэгдсэн Улсын

“Ирээдүйн Манлайлагчдын Солилцооны” хөтөлбөр

Монгол улс болон Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тохиолдуулан АНУ-ын Засгийн газраас санхүүжилттэй Ирээдүйн Манлайлагчдын Солилцооны Хөтөлбөрийг (FLEX) Монгол улсад 2017 онд хэрэгжүүлж эхлэхээр шийдвэр гарсан.

Үүний дагуу Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага Америкийн Олон Улсын Боловсролын Зөвлөл хамтран ажиллахаар хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг зурсан.

АНУ-ын Засгийн газрын санхүүжилттай бүрэн тэтгэлэгт FLEX хөтөлбөр нь Монголын бүрэн дунд сургуулийн сурагчдад Америкийн Нэгдсэн Улсын ахлах сургуульд 1 жил үнэ төлбөргүй сурч Америк гэр бүлийн нэг гишүүн нь болж амьдрах боломжийг олгодог урт хугацааны солилцооны хөтөлбөр юм.



Шалгуур үзүүлэлт:

Солилцооны хөтөлбөр (Хугацаа: 8-9 дүгээр сар)

Солилцооны хугацаа	1 жилийн хугацаатай солилцоо
Шалгуур үзүүлэлт	<p>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;</p> <ol style="list-style-type: none">1. Оролцох үедээ 9, 10, 11 дүгээр ангийн сурагч байх;2. Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;3. Сурлагын үнэлгээний дундаж нь 80% түүнээс дээш байх;4. Монгол улсын иргэн, гадаад паспорт авах эрхтэй байх;5. Насны шалгуурыг жил бүр тодорхойлж зарлана;6. Америкт зорчих визний шалгуур хангасан байх. <p>Анхааруулга</p> <ul style="list-style-type: none">▪ Оролцогч зөвхөн нэг л шалгалт авах байранд шалгалт өгч болно.▪ Шалгалтын танхимд утас авч орохыг хориглоно.▪ Зарласан шалгалтын цагаас хоцорсон бол дундуур нь орох боломжгүй.▪ 1, 2 дугаар шат нэг өдөр болох учраас (Улаанбаатарт өөр өдөр болно) хүлээх зуураа идэх хоолоо авч ирнэ. <p>Америкийн Зөвлөлийн төлөөлөгчид:</p> <ul style="list-style-type: none">▪ Өвөрхангай аймаг, Арвайхээр хот▪ Ховд аймаг, Ховд хот▪ Дорнод аймаг, Чойбалсан хот▪ Улаанбаатар хот

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

1



Шалгуулагчийг урьдчилсан бүртгэл хийлгүй шалгалт өгөх байранд төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, цээж зураг, хар үзгэн балтай ирж шууд 1 дүгээр шатны шалгалтанд орно.

1 дүгээр шатны шалгалтанд сурагчид англи хэлний дундаас дээш түвшний дүрмийн мэдлэгийг 16 асуултанд 15 минут хариулах сорил /тест/-оор шалгуулна.

2



1 дүгээр шатнаас шалгарсан хүүхдүүд 2 дугаар шатны шалгалтанд орно. 2 дугаар шатанд сурагчид богино хэмжээний эссе бичих бөгөөд АНУ-ын Вашингтон хотруу цахим шуудангаар эссе илгээж, 1 хоногийн дараа хариуг ирүүлнэ. Сурагчдын бичсэн эссе хэрхэн зөв бичгийн дүрмээр бичсэнээр нь биш утга агуулгаар нь дүгнэдэг. Эссений сэдэв нь ихэвчлэн амьдралд тохиолдож байсан зүйлсийн тухай асуусан байдаг.

3



2 дугаар шатыг амжилттай давсан оролцогч 3 дугаар шатанд өргөдлийн материал хүлээн авч дахин англи хэлний сорил өгч англи-монгол хэлээр ярилцлаганд орно. Шалгаруулалтын бүх материалууд АНУ-ын Вашингтон хот руу илгээгдэж Америк мэргэжилтнүүдээс бүрдсэн бие даасан комисс хөтөлбөрийн үндсэн оролцогчдыг шалгаруулдаг, шалгаруулалт нь сурагчдын ерөнхий чадвар дээр суурилдаг.

4



Тэнцсэн оролцогчид АНУ-д солилцооны хөтөлбөрт оролцох болно.